

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая

Онигири хийгээд, гадагшаа гараарай!



Онигиригийн түүх эртнээс эхэлсэн бөгөөд 1300 орчим жилийн өмнөх Нарагийн үеийн номонд “握飯 (にぎりい)” гэсэн бичвэр үлдсэн байна. Үүний дараа, Эдогийн үе (европ тооллын 1603 он)-д зам тавигдсанаар, хүмүүс наашаа цаашаа явах нь түгээмэл болж, хийхэд хялбар бөгөөд идэхэд амар онигири бариад гадагшаа гарах болсон гэж үздэг. Одоо бол доторх хачир нь улам төрөлжсөн ба 24 цагийн дэлгүүр зэрэг газруудаас амархан худалдаж авах боломжтой болсон нь ч түлхэц болон, Японд маш танил хоол болсон. Сүүлийн үед онигиригээр дагнасан дэлгүүр ч олширсон ба худалдаж авахад дугаарладаг, олны танил болсон дэлгүүр ч байдаг. Япон даяар сакура цэцэг цэцэглэж, гадагшаа гарахад хамгийн тохиромжтой улирал болно. Мөн, голден вийк гэгдэх олон хоног үргэлжлэх амралт ч байна. Та бүхэн ч гэсэн амралтын өдрөөрөө онигири хийгээд, гадагшаа гарч үзээрэй.

“とも/Томо” нь, Японд амьдрахад хэрэг болох мэдээлэл, Япон хэл сурахад хэрэг болох зүйлс зэргийг, дуудлагыг нь хадсан Япон хэл болон гадаадын 9 орны хэл (Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбодж, Мьянмар, Монгол, Англи) дээр гаргадаг. Япон хэл дээрх хувилбарыг товхимол хэлбэрээр хүргэдэг ба гадаад хэл дээрх хувилбарыг JITCO-гийн цахим хуудаснаас ухаалаг утас зэргийг ашиглан, PDF хэлбэрээр харах боломжтой. Та бүхэнд орж харахыг санал болгож байна. (<https://www.jitco.or.jp/ja/tomo/>)





“Оршин суух үнэмлэх”

-ээ гээхгүй байхын тулд анхааралтай байцгаая

Та бүхний байнга биедээ авч явдаг оршин суух үнэмлэхийг явсан газартаа гээх тохиолдол нэмэгдэж байна. Тиймээс, энэ удаа, оршин суух үнэмлэх гэж юу болох, юунд анхаарвал зохих талаар дахин мэдэгдье.

Оршин суух үнэмлэх гэж юу вэ?

Оршин суух үнэмлэх нь 3 сараас дээш, тодорхой хугацаагаар Японд оршин суух гадаадын бүх иргэдэд олгогддог үнэмлэх юм. Ном ёсоор нь зөвшөөрөл аваад Японд оршин сууж байгаа гэдгийг Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газрын дарга гэрчлэх чухал үнэмлэх юм. Төрийн

байгууллага дахь нягтлан магадлах ажил, банкны данс нээлгэх, эрүүл мэндийн даатгалын процедур зэрэг нийгмийн амьдралын аливаа тохиолдолд хэрэглэгддэг тул, нийгмийн найдвартай байдал нь хангагдсан байх шаардлагатай бөгөөд төрөл бүрийн дүрэмтэй.

Яагаад биедээ авч явахгүй бол болохгүй юм бэ?

Хуурамч биеийн байцаалттайгаар Японд оршин суух гадаад иргэд болон оршин суух хугацаа нь хэтэрсэн байсан ч оршин суусаар байгаа гадаад иргэдийг Японоос албадан нутаг буцааж болно. Өмнө дурьдсанчлан, оршин суух үнэмлэх нь, ном ёсоор нь зөвшөөрөл аваад Японд оршин сууж байгаа гэдгийг гэрчлэх үнэмлэх учраас, та бүхэн оршин суух

үнэмлэхийг биедээ авч явснаар, та бүхний оршин суугчийн статус, биеийн байцаалтыг түргэн нягтлах боломжтой. Өргөдөл гаргах процедурын үе г.м тохиолдолд Хянан зохицуулагч байгууллага болон ажил эрхэлж буй компанийхаа хүнд түр хадгалуулсан байсан ч, эргүүлж авсныхаа дараа бол заавал биедээ авч яваарай.

“Хийх шаардлагатай зүйл” ба “Хийж болохгүй зүйл”

● Хийх шаардлагатай зүйл юу вэ?

- ☒ Оршин суух үнэмлэхээ байнга биедээ авч яваарай. Цагдаагийн ажилтан оршин суух үнэмлэхээ үзүүлэхийг шаардвал, үзүүлээрэй. Биедээ авч яваагүй тохиолдолд, 200,000 иен хүртэлх хэмжээний мөнгөн торгууль ноогдуулна.
- ☒ Оршин суух үнэмлэхээ гэж үрэгдүүлсэн, гэмтээсэн, бохирдуулсан тохиолдолд, тухайн байдлыг мэдсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор, ойрхон байгаа Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газрын орон нутаг дахь салбарт дахин олгохыг хүссэн өргөдөл гаргаарай. Оршин суух үнэмлэхээ гэж үрэгдүүлсэн, гэмтээсэн, бохирдуулсан гэдгээр торгууль ноогдуулахгүй хэдий ч, оршин суух үнэмлэхийг дахин олгохыг хүссэн өргөдлийг заасан хугацааны дотор гаргахгүй бол 1 жил хүртэлх хугацааны хорих ял эсвэл 200,000 иен хүртэлх хэмжээний мөнгөн торгууль ноогдуулна.
- ☒ Оршин суугаа газраа өөрчилсөн тохиолдолд, хот/дүүрэг/тосгоныхоо захиргааны газарт мэдэгдэл гаргах шаардлагатай. 14 хоногийн дотор мэдэгдэл гаргахгүй бол 1 жил хүртэлх

хугацааны хорих ял эсвэл 200,000 иен хүртэлх хэмжээний мөнгөн торгууль ноогдуулна.

- ☒ “Японд оршин суух хугацаа (дуусгавар болох өдөр)”-г хэтрүүлэн Японд оршин сууж болохгүй. Оршин суух үнэмлэхний хүчинтэй хугацаа дуусгавар болох өдрөөс урьтан Японд оршин суух хугацааг шинэчлэх өргөдөл гаргах шаардлагатай. Энэ тохиолдолд, шинэ оршин суух үнэмлэх олгогдоно. Өргөдөл гаргахгүй бол 1 жил хүртэлх хугацааны хорих ял эсвэл 200,000 иен хүртэлх хэмжээний мөнгөн торгууль ноогдуулна.

● Хийж болохгүй зүйл юу вэ?

- ☒ Оршин суух үнэмлэхийг хэн нэгэнд түр өгч, бүр өгч болохгүй. Хугацаа нь дуусан үнэмлэх байсан ч мөн ижил. Муугаар ашиглагдах аюултай. Муугаар ашиглагдахыг нь мэдэж байсан хэрнээ, оршин суух үнэмлэхээ хэн нэгэнд өгвөл, 1 жил хүртэлх хугацааны хорих ял эсвэл 200,000 иен хүртэлх хэмжээний мөнгөн торгууль ноогдуулж, албадан нутаг буцааж болно.

出典：出入国在留管理庁ホームページ

https://www.moj.go.jp/isa/applications/procedures/whatzairyu_00001.html

https://www.moj.go.jp/isa/applications/faq/newimmiact_4_point.html

https://www.moj.go.jp/isa/publications/faq/newimmiact_4_port-city.html

https://www.moj.go.jp/isa/publications/faq/newimmiact_4_q-and-a_page2.html



“Япон цай”-ны тухай бага зэрэг гүнзгийрүүлэн авч үзье

Японд үйлдвэрлэгддэг ногоон цайг “Япон цай” гэж хэлдэг ба ногоон цай гэдэг нь цайны модны навч (цайны навч)-ийг түүж, боловсруулсан цай юм. Үүн дотроо тухайн жилийн 5-р сарын эхэнд худалдаанд гардаг цайг “Шинэ цай” гэдэг бөгөөд шинэ цайны ногооноор баялаг амт нь чанга, сэргэх таатай үнэртэй байдаг. Шинэ цайг халуун ууж ч болох ба “хүйтэн усны цай” гэгддэг хүйтнээр уудаг цай ч мөн сэргэдэг, гойд юм. Мөн, ногоон цайнд ихээр агуулагддаг “катехин” нь бактери болон

вирусийн эсрэг үр нөлөөтэй гэж үздэг бөгөөд үүний эрүүл мэндэд үзүүлэх үр нөлөө нь ч анхаарал татаж байна. Сүүлийн үед матча хэрэглэсэн “матча латте” зэрэг ундааг кафе д очиж уудаг хүн ч олон байна. Та бүхэн ч гэсэн өөрийнхөө дуртай цайг олоод, Япон цайг амтархаарай.

Цайны голлох төрөл



煎茶
せんちゃ

Ногоон цайны дотроо хамгийн түгээмэл цай. “Энгийн 煎茶/сэнча”-гаас гадна, гашуун амт багатай, зөөлөн амттай “Удаан жигнэсэн 煎茶/сэнча” ч байдаг.



玉露
ぎょくろ

Ерөнхийдөө дээд зэрэглэлийн цай гэдгээрээ танигдсан ба баялаг амттай, хүчтэй умами болон нялуун амт нь уг цайны онцлог. Аманд орох үед хамар цоргисон, онцлог бүхий үнэр нь “далайн ногоон байцаа мэт” хэмээн илэрхийлэгдэх нь ч бий.



番茶
ばんちゃ

Нутаг нутгаараа үйлдвэрлэх арга нь харилцан адилгүй боловч ерөнхийдөө сунаж хатуурсан цайны навч, ишийг үндсэн материал болгодог. Гашуун амт багатай, уухад хялбар цай юм.



ほうじ茶
ほうじちゃ

Доод зэрэглэлийн 煎茶 /сэнча болон 番茶/банча зэргийг хүчтэй гал дээр хуурсан цай. Таатай үнэртэй, уусны дараа сэргэдэг амт нь уг цайны онцлог.



抹茶
まっちゃ

Ердийнхөөс өөр аргаар тариалж, цайны навчийг үрэлгүйгээр хатааж, илүүдэл зүйлийг нь зайлуулсан цайг цайны тээрмээр нарийн ширхэгтэй нунтагласан цай. Цайны ёслолд хэрэглэгдэхээс гадна, 抹茶/матчатой амттан болон гурвалжин будааны гурил д 抹茶/матча хольж хийдэг, цайтай гурвалжин будааны гоймон зэргээр өргөн хүрээнд хэрэглэгдэж байна.

Кокуго-но-мори

Энэ нь Япон хэлний үг хэллэг, ханз болон эдгээрийн хэрэглэх аргын талаар суралцахад зориулсан сурах бичиг болно. Зугаатайгаар хариуг нь бодож олцгооё. (Хариу нь дараагийн хуудсанд байгаа.)



☐
 車もがなばれ。
 クルマもがなばれ。

☐
 きょうそうしてるよ。
 きょうそうしてるよ。

☐
 、こんでいる。
 、こんでいる。

☐
 乗る。
 のる。

☐
 ドアが開いた。
 ドアが開いた。

☐
 来た。
 きた。

☐
 まつ。
 まつ。

☐
 行こう。
 行こう。

どれも「電車」から始まります。下の言葉とつながる一字の言葉を□に書きましょう。

小さいくても大事な言葉



こくごのもり



指導・元世田谷区立
しょうがっこう
小学校教諭
なかほし れいこ
高橋 伶子
イラスト・奈良 恵



Өнгөрсөн жил мөн зохион байгуулагдсан футзалын тэмцээнд Индонези, Вьетнамаас ирсэн ур чадварын дадлагажигч, тусгай ур чадвартай гадаад иргэн 60 орчим хүн оролцож, халуун өрсөлдөөнтэй тэмцээн боллоо. Тэргүүний медалийг хүзүүндээ зүүсэн тэмцээнд оролцогчдын нүүр дүүрэн инээмсэглэсэн зураг. Спорт оор дамжуулан янз бүрийн холбоо харилцаа бий болж, үр өгөөжтэй нэгэн өдрийг өнгөөрөөжээ.

※2024年12月投稿 監理団体：協同組合ビジネスプラザ

Оролцохыг урьж байна.

Ур чадварын дадлагажигчийн хүлээн авагч байгууллагуудаас JITCO-гийн цахим хуудсанд ирүүлсэн “Ур чадварын дадлагын Days”-ээс нэг зургийг сонгон нийтэлж байна. “Ур чадварын дадлагын Days” хуудас болон зураг ирүүлэх удирдамжийг эндээс харна уу.

(<https://www.jitco.or.jp/ja/days/>)



Ур чадварын дадлагажигч гадаад иргэдийн Япон хэлний зохион бичлэгийн 33-р уралдааны танилцуулга

JITCO нь 4-р сарын 1 (Мягмар гараг)-наас Япон хэлний зохион бичлэгийн уралдаанд оролцох бүтээлийг хүлээн авна. Бүтээл ирүүлэх цаад хугацаа: 5-р сарын 9 (Баасан). Уралдааны дэлгэрэнгүй удирдамжийг JITCO-гийн цахим хуудас (<https://www.jitco.or.jp/>), JITCO Япон хэлний сурах бичгийн хироба (талбай) (<https://hiroba.jitco.or.jp/>)-гийн “Мэдээлэл”-д нийтэлсэн байгаа. Та бүхнийг уралдаанд оролцохыг урьж байна!



助詞は、語と語、句と句の間にあって、言葉と言葉との続き具合や意味をはっきりさせる働きをします。
言葉の終わりにつく「か・よ・ね・ぞ・の……」もあれば、「でも・しか・だって・まで・だけ・ほど・くらい……」などもあります。この小さな言葉なくしては、必要なことを十分に伝えることができません。



◆ここへこたえ

Залгавар нь үг хооронд, өгүүлбэр хооронд орж, үг хоорондын үргэлжлэл болон утгыг нь тодорхой болгох үүрэгтэй. Үгийн төгсгөлд ордог “か/ка, よ/ё, ね/нэ, ぞ/зо, の/но……” ч байдаг бол, “でも/дэмо, しか/шика, だって/даттэ, まで/мадэ, だけ/дакэ, ほど/ходо, くらい/курай……” зэрэг ч байдаг. Эдгээр бяцхан үгнүүд байгаагүй бол, хэрэгтэй юмаа хангалттай хэлж ярьж чадахгүй юм.

とも

2025年4月 春季号

2025年4月1日発行

発行

電話
JITCO ホームページ

公益財団法人 国際人材協力機構 (JITCO)
総務部広報室
〒108-0023
東京都港区芝浦2-11-5
五十嵐ビルディング
03-4306-1166 (ダイヤルイン)
<https://www.jitco.or.jp/>



jitco.official



@jitco_official